



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/379

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "а", Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.8, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах, нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлах зорилгоор сонины тусгай дугаар бэлтгүүлэн ажиллахад 3,550,000 (гурван сая таван зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011865

08 Аймгийн Засаг даргын 2021 оны
дугаар сарын 10 өдрийн 12/379
дугаар захирамжийн хавсралт

№	Зориулалт	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Дүн /төгрөг/
1	Тусгай дугаар	15,000	170	2,550,000
2	Эх бэлтгэлийн зардал	1	1,000,000	1,000,000
Нийт дүн				3,550,000